

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... сарын ... ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, тус сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ, эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалтыг тогтоох, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Хүний хөгжил сангийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР, ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ

3 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн төсөвт 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 549,780.0 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөг/
1	Сангийн сайд	534,780.0
	1.1.Татварын ерөнхий газар	534,780.0
	1.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	534,780.0
2	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	15,000.0

	2.1.Төрийн өмчийн хороо	15,000.0
	2.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	15,000.0

4 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн төсвөөс 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 312,064.2 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөг/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	257,453.5
	1.1.Төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,033.2
	1.2.Хүүхдийн мөнгө	240,000.0
	1.3. Хөрөнгө оруулалт	5,420.3
2	Сангийн сайд	292,326.5
	2.1. Засгийн газрын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	54,610.7
	2.1.Урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөрт	157,129.1
	2.2.Засгийн газрын бондын үндсэн төлбөрт	80,586.7
	2.3.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

5 дугаар зүйл. Хүний хөгжил санд 2014 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 0.00 төгрөг байхаар баталсугай.

6 дугаар зүйл. “Хүний сангийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	/сая. төгрөг/ 2014 онд санхүүжих
	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд		5,420.3	5,420.3
1.	Хөрөнгө оруулалт		5,420.3	5,420.3
1.1	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.2	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.3	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.4	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.5	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014-2014	923.1	923.1